

## ДОРНОД АЙМГИЙН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

### **Гол үзэл санаа:**

- Залуучуудын утга учиртай оролцоог хангана
- Бүтээлч, хариуцлагатай, ёс зүйтэй шинэ үеийн залуучуудыг төлөвшүүлнэ
- “Бид Дорнодын Залуус” бахархалыг бий болгоно
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, амьдралын чанарыг дээшлүүлнэ

### **Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ:**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1985-1995 оныг Залуучуудын арван жил болгон зарлаж, 1995 онд НҮБ-аас дэлхийн залуучуудын үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан нь дэлхий нийтээрээ залуучуудын асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх, тэдний нийгмийн оролцоог дээшлүүлэх боломжийг улам бататгасан юм.

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсанаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын бүтцийг бий болгон улмаар Монгол улс анх удаа Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуультай болохоор зорьж байна.

Мянганы дээд хэмжээний чуулга уулзалтаас 21 дүгээр зуунд дэлхийн улс орнууд хөгжлийн төлөө хамтран ажиллахаар баталсан "Мянганы хөгжлийн зорилтууд"-ын дийлэнх нь "Нийгмийн хөдөлгөгч хүч" залуучуудын амьдралтай шууд холбоотой асуудал бөгөөд тэдний идэвхитэй оролцоогүйгээр хэрэгжүүлэх, үр дүнд хүрэх бололцоогүй юм. Иймд шинэ үеийн залуучуудын өөрсдийн оролцоонд суурилсан бодлогыг хэрэгжүүлэх үзэл баримтлалыг чухалчлан Дорнод аймгийн Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж байна.

Монгол Улсын хүн амын насны бүтцийг дэлхийн бусад орны хүн амын насны бүтэцтэй харьцуулахад харьцангуй залууд тооцогдох бөгөөд Дорнод аймаг 2016 оны статистикаар нийт 77772 хүн амтай ба үүнээс 18-34 насны залуучууд 24159 буюу нийт хүн амын 31 %-ийг эзэлж байна.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас төрийн болон төрийн бус байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөр эрхлээгүй байгаа 200 гаруй өсвөр үе, залуучуудаас судалгаа авч нэгтгэхэд оролцогчдын 33% нь залуучуудын орон байрны хэрэгцээг хангах шийдлүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх, 18% нь залуучуудын хөдөлмөр эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх, 28% нь боловсролыг чанартай, хүртээмжтэй байлгах, 13% нь эрүүл мэндийг хамгаалах, 7% нь нийгмийн дэмжлэг хэрэгтэй зорилтот бүлгийн залуучуудад зохистой арга, хэлбэрээр хүрч ажиллах чухал байна гэсэн байна.

Энэхүү хөтөлбөр нь орон нутгийн залуучуудад тулгамдаж буй нийтлэг асуудал, бэрхшээлийг тодорхойлж, залуучуудын утга учиртай оролцоог нэмэгдүүлэх замаар түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, залуучуудын хөгжлийн хэрэгцээг хангах зорилгоор Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2016-2025 /Хүн төвтэй нийгмийн хөгжлийг хангах, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх үзэл баримтлал/, Дорнод аймгийн хөгжлийн цогц бодлого, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /2.4.1 Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, нийгмийн

харилцаанд адил тэгш оролцох боломжоор хангах ажлын хүрээнд/-ийг хэрэгжүүлэхтэй нягт уялдаатай хэрэгжих юм.

**Хоёр. Хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим:**

- Хөтөлбөрийн зорилго тодорхой, зорилтот үйл ажиллагаа нь залуучуудын эрэлт хэрэгцээнд нийцэхүйц байх
- Залуучуудын эрхийг дээдэлсэн, тэгш хүртээмжтэй байх
- Оролцогч талуудын хамтын ажиллагаа, үр ашигтай түншлэл, залуучуудын утга учиртай оролцоо, санаачлагад тулгуурласан байх
- Хөтөлбөр нь Үндэсний болон орон нутгийн бодлого хөтөлбөр, төлөвлөлт, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоонд тулгуурлах
- Гадаад, дотоодын сайн туршлага, олон улсын жишигт баримжаалсан, өндөр бүтээмжтэй, үр дүнтэй байх

**Гурав.Хамрах хүрээ:**

- Дорнод аймгийн 18-34 насны залуучууд
- Бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллага/баг, сум, аймаг/
- Бүх шатны нутгийн захиргааны байгууллага /баг, сум, аймаг/
- Төр, иргэний нийгмийн байгууллагууд
- Залуучуудын сайн дурын байгууллага, сонирхлын бүлгүүд
- Хэвлэл, мэдээллийн байгууллагууд

**Дөрөв. Хөтөлбөрийн зорилго:**

Орон нутгийн залуучуудын хөгжлийг дэмжиж, нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх замаар эрүүл бие бялдартай, эх нутагтаа ажиллаж хөдөлмөрлөх, бүтээлч хариуцлагатай, амьдрах ухааны чадвартай залуу үеийг төлөвшүүлэхэд оршино.

**Тав. Хөтөлбөр хэрэгжих хугацаа:**

2017-2020 он хүртэл 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

**Зургаа. Хөтөлбөрийн зорилт**

1. Аюулгүй амьдрах, хөгжих ээлтэй орчинг бүрдүүлэх замаар орон нутгийн хөгжилд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх
2. Залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл чийрэг бие бялдартай, бүтээлч залуучуудыг бэлтгэх
3. Залуучуудын сурч, хөгжих, хөдөлмөрлөх таатай нөхцлийг бүрдүүлэх
4. Залуучуудад амьдрах ухааны зөв дадал олгож, залуу гэр бүлд дэмжлэг үзүүлэх

**Долоо.Хүрэх үр дүн:**

- Дорнод аймаг эрүүл аюулгүй, тав тухтай амьдрахад хамгийн тохиромжтой залуучуудад ээлтэй аймаг болсон байна.
- Залуучууд сайн дурын үндсэн дээр жилд 1 удаа эрүүл мэндийн иж бүрэн үзлэг оношлогоонд хамрагддаг дадал хэвшсэн байна.

- Залуучуудын мэдлэг боловсрол, амьдрах ухааны ур чадвар дээшилж, залуучуудын хөдөлмөр эрхлэлт 40 хувиар өссөн байна.
- Залуучуудын гэр бүл төлөвлөлт сайжирч, гэр бүлийн өмнө хүлээх хариуцлага дээшлэхэд нөлөөлсөн байна
- Залуучуудын нийгмийн идэвхи оролцоо, нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, бүтээлч хандлага дээшилсэн байна.
- Дорнод аймгийн залуучуудын бүтээлч, хариуцлагатай байдал, эерэг хандлага бусад аймаг, хотын залуучуудад сайн үлгэр дууриалал болсон байна.

**Найм. Удирдлага, зохион байгуулалт:**

- Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Залуучуудын төрийн болон төрийн бус байгууллага, нэгдэл, клуб, зөвлөл, хэвлэл мэдээлэлийн байгууллагын төлөөлөл оролцсон хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөлийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөл нь нэгдсэн төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст нэгтгэж, аймгийн Засаг даргын зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд жил бүр тайлагнана.
- Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд өгсөн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн зөвлөмж гаргаж, цаашдын үйл ажиллагаанд тусгаж ажиллана.
- Хөтөлбөр нь орон нутгийн Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллага, сайн дурын үүсгэл санаачлагын байгууллага, хэвлэл мэдээлэлийн байгууллагуудын хамтын ажиллаганы хүрээнд хэрэгжих бөгөөд холбогдох байгууллагууд хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд гарч буй ололт амжилт, ахиц өөрчлөлт, үр дүнг олон нийтэд мэдээллэх, сурталчлах үйл ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулна.
- Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлнэ.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээ тайланг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд, ил тод, нээлттэй мэдээлнэ. [www.dornod.nac.gov.mn](http://www.dornod.nac.gov.mn), /Гэр бүл Хүүхэд Дорнод, Dornod Zaluuchuudiiin hugjliin tuw/ facebook хуудас

**Ес.Хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл:**

**Зорилт-1. Аюулгүй амьдрах, хөгжих ээлтэй орчинг бүрдүүлэх замаар орон нутгийн хөгжилд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх**

1.1 “Нутгийн хөгжилд Залуучуудын манлайлал” аймгийн залуучуудын чуулга уулзалт болон Залуучуудаа сонсох өдрийг зохион байгуулж, залуучууд үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын санал бодлыг хүргэж, орон нутгийн бодлого шийдвэрт залуучуудын оролцоог хангах

1.2 Өсвөр үе, залуучуудад өөрийгөө илэрхийлэх, биеэ зөв авч явах чадвар төлөвшүүлэх, манлайлал, харилцаа, илтгэх ур чадварт суралцуулахад иргэний нийгмийн байгууллагын санаачлагыг дэмжиж, хамтран ажиллах

1.3 Залуу багш, Залуу эмч, Залуу инженер гэх зэрэг мэргэжилд түшиглэсэн залуучуудын сайн дурын байгууллагуудыг /клуб, зөвлөл, нэгдэл, холбоо/ байгуулах санаачлагыг дэмжиж, үе тэнгийн залуучуудад зориулсан сургалт, сурталчилгаа, сайн туршлагыг түгээх, зөвлөх үйлчилгээг нэвтрүүлэх

1.4 Орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн “Шинэ үеийн илгээлтийн эзэн” хөдөлгөөнийг өрнүүлэхэд залуучуудын сайн дурын байгууллага болон орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран ажиллах

1.5 Залуучуудын асуудлаар дэлхийн болон олон улсын хэмжээнд зохион байгуулагдсан хурал, чуулганд залуучуудын төлөөлөлийг тогтмол оролцуулж, чуулганы бодлого шийдвэрийг тэднээр дамжуулан сурталчлах

1.6 Төрөл бүрийн салбарт онцгой амжилт гаргасан олны танил залуучуудын оролцоотойгоор Залуучуудын талаарх хууль тогтоомж, орон нутгийн бодлого хөтөлбөрийг олон нийтэд таниулан сурталчлах, залуучуудыг эерэг зан үйлд уриалсан нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулж, сайн засаглалыг хөгжүүлэх

1.7 Залуучуудын спорт, урлаг соёлын наадмыг зохион байгуулах санал санаачлагыг дэмжиж, 2 жилд нэг удаа сумдын залуучуудын бага наадам, 4 жилд нэг удаа аймгийн Залуучуудын их наадмыг зохион байгуулах

1.8 Ардын урлаг, уламжлалт тоглоом наадгайг хөгжүүлэх хөдөлгөөн өрнүүлэхэд залуучуудын оролцоог хангах

1.9 Орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулж, үр бүтээлтэй ажиллаж байгаа төрийн болон иргэний нийгмийн байгууллагын залуучуудыг алдаршуулах, урамшуулах

1.10 Хэл ярианы бэрхшээлтэй залуучуудад нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дохионы орчуулагч бэлтгэх сургалтыг /төрийн ба үйлчилгээний байгууллагуудад/ үе шаттайгаар зохион байгуулах, дохионы орчуулгатай мэдээ мэдээлэлийг орон нутгийн телевизээр тогтмол нэвтрүүлэх

1.11 Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд зорчих зам талбай, олон нийтийн газар, нийтийн тээврийн хэрэгсэл, нийтийн бие засах газрын стандарт шаардлагыг хангах түвшинд хүргэхэд нөлөөлөх

1.12 “Ногоон дэлхий, эх нутгаа хайрлая” компанит ажлыг салбар бүрийн төлөөлөл залуучуудыг хамруулан жил бүр зохион байгуулж, залуучуудад төрөлх нутгаараа бахархах үзлийг төлөвшүүлэх

1.13 Байгаль орчныг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх, экологийн боловсрол олгох мэдээлэл сурталчилгааг залуучуудын оролцоотой зохион байгуулах, хялбаршуулсан ухуулга, сурталчилгааны материалыг түгээхэд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах

1.14 Залуучуудыг хөдөлмөрийн харилцаан дахь шууд болон шууд бус ялгаварлал, ажлын байран дахь дарамт, хүчирхийлэлд өртөж байгаа талаарх мэдээллийг нээлттэй болгох, хяналт тавих улмаар түүнийг арилгах арга хэмжээг тэдний оролцоотойгоор зохион байгуулах

1.15 Дорнодын залуучуудын үнэт зүйл, эрхэм зорилгыг тодорхойлох бүх нийтийн санал асуулгыг цахим сүлжээ болон бусад хэлбэрээр явуулж, залуучуудын оролцоотойгоор Дорнодын залуучуудын эрхэмлэх зүйлсийг бий болгон сурталчлах ажлыг өрнүүлэх

1.16 Залуучуудыг авлига, ашиг сонирхлоос ангид байх, хувь хүний болон хотын соёлыг түгээх манлайлагч 50 залуучуудыг жил бүр бэлтгэн тэднээр дамжуулан

зөв зан үйлийг залуучуудад төлөвшүүлэх “Бид Дорнодын залуучууд” аяныг зохион байгуулах

1.17 Залуучуудын эрхийг хангах талаар чиг үүрэг хүлээсэн төрийн болон төрийн бус, сайн дурын байгууллагуудын чадавхийг бэхжүүлж, хамтын ажиллагааг дэмжих

## **Зорилт-2. Залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл чийрэг бие бялдартай, бүтээлч залуучуудыг бэлтгэх**

2.1 Залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургагч багш нарыг жил бүр бэлтгэн, ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг тасралтгүй дэмжиж, залуучуудын өмнө тулгамдаж буй асуудалд залуус, залуусдаа нөлөөлөх арга зүйг хөгжүүлэх

2.2 Залуучуудад эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамирыг сурталчилсан “Эрүүл мэндийн цаг” нэвтрүүлгийг бэлтгэн, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх

2.3 Залуучуудад осол гэмтлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чиглэлээр мэдлэг олгох сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах

2.4 Залуучууд олноор цуглардаг үйлчилгээний газарт гарч болзошгүй осол, аюулаас сэргийлэх санамж, зааварчилгаа байрлуулах, зөв хооллох, амрах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулах үүсгэл санаачлагыг дэмжих

2.5 Залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлыг бүх түвшинд тогтмол зохион байгуулж, урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд хамруулах ажлыг өрхийн эмнэлэг, сургууль, албан байгууллагуудтай хамтран жилд 1 удаа зохион байгуулах, сайн дураараа хамрагдаж байх дадлыг хэвшүүлэх /Цэргийн насны залуучуудыг 100% хамруулах/

2.6 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, залуучуудад ээлтэй, эрүүл орчинг бүрдүүлэх чиглэлээр “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” болох хөдөлгөөнийг идэвхижүүлэх

2.7 Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын эрүүл мэндийн тусгай хэрэгцээг хангахад нийгэм, хамт олонд түшиглэсэн нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг өргөжүүлэх

2.8 Залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх спорт заал болон алжаал тайлах, бялдаржуулах, иог, бясалгалын төв зэрэг тэдэнд ээлтэй үйлчилгээг нэвтрүүлж буй хувийн хэвшил, аж ахуй нэгжүүдийг хөхиүлэн дэмжих

2.9 Их, дээд сургууль, цэргийн анги нэгтгэлүүд, цагдаа, хуулийн болон боловсрол, эрүүл мэндийн байгууллага зэрэг залуучууд олноор сурч, хөдөлмөрлөдөг байгууллага аж ахуй нэгжид нөхөн үржихүй, бэлгийн замын халдварт өвчлөлийн талаар сургалт, мэдээлэл өгч, залуучуудыг халдварт өвчлөлөөс өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг олгох

2.10 Нийтээр тэмдэглэх баяр, ёслолын өдрүүдийг архи, тамхигүй зөв боловсон өнгөрүүлэх, архи, тамхины хэрэглээг бууруулах, мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх талаар идэвхтэй ажиллаж байгаа байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх

2.11 Залуучуудад архи, тамхи, мансууруулах бодисын хор уршиг тэдгээрийг тохиолдлын чанартай хэрэглэхээс урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх,

мансууруулах, сэтгэцийн үйл ажиллагаанд нөлөөлдөг эмийн борлуулалт, түүнийг сурталчилж буй хууль бус үйл ажиллагаанд хяналт тавихад залуучуудын оролцоог нэмэгдүүлэх

2.12 Өндөр эрсдэлтэй эмзэг бүлгийн залуучууд, түүний дотор ажил, сургуульгүй, орлогогүй залууст бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, ХДХВ-ийн нэр хаяггүй сайн дурын шинжилгээ, бэлгийн эрүүл мэндийн зөвлөгөө авах үйлчилгээг зохион байгуулах санаачлагыг дэмжих

2.13 Залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлж, эрт төрөлт, хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх, эрсдэлгүй зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх

### **Зорилт-3. Залуучуудын сурч, хөгжих, хөдөлмөрлөх таатай нөхцлийг бүрдүүлэх**

3.1 Боловсрол, эрүүл мэнд, амьдрах урлаг, үл хөдлөх хөрөнгө зуучлал, мэргэжлээ зөв сонгох, ажлын байрны захиалга авах, холбон зуучлахад туслах, орон нутагт хамгийн эрэлт хэрэгцээтэй мэргэжил болон дутагдалтай байгаа ажлын байр зэрэг хувь хүний хөгжилд хэрэгцээтэй судалгаа, мэдээллийн өргөн багтаамж бүхий нэгдсэн цахим сан бүрдүүлж, “Дорнод инфо-Залуучууд” гэсэн цахим үйлчилгээг бий болгох

3.2 Улс, бүс, дэлхийн хэмжээнд хичээл сургалт, урлаг, спортоор амжилт гаргасан болон гоц авьяастай, оюуны өндөр чадвартай залуучуудын оюуны бүтээлийг дэмжих, гадаад, дотоодын их, дээд сургуулиудад бакалавр, магистр, докторын хөнгөлөлттэй сургалтын хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлэх аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлгийг жил бүр 3 /гурав/ хүртэлх оюутанд олгох, ажлын байр, цалин хөлс, нийгмийн баталгаагаар хангах

3.3 Төрийн болон төрийн бус байгууллага, залуучуудын сонирхлын бүлгүүдээр дамжуулан залууст бизнес, менежмент, маркетинг, хууль эрх зүй, санхүүгийн боловсрол олгох, эрүүл мэнд, нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах

3.4 Залуучуудыг номтой нөхөрлүүлэх улмаар сум орон нутгийн номын санг цахимжуулах, музей, соёлын төвийн үйлчилгээг залуучуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн өргөтгөх, шинэ загвар технологиор засварлаж, залуучуудын бие даан суралцах, мэдээлэл авах хөгжлийн төв болгон ашиглалтыг нэмэгдүүлэх

3.5 Залуу хүн бүр үндэсний бичиг, хэл, соёлоо сайтар судлан суралцах улмаар гадаад хэл сурахыг уриалсан хөдөлгөөн өрнүүлэх

3.6 Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын сурч, боловсрох, хөдөлмөрлөх нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

3.7 Мэргэжлийн сургалтын байгууллагыг түшиглэн Бизнес инкубатор үйлчилгээг төгөлдөржүүлж, залуучуудын гарааны бизнесийг дэмжих улмаар ажилтай, орлоготой, амьдралын ухаантай залуучуудыг бэлтгэх

3.8 Залуу малчдыг бэлтгэх, залуу үеийн мал аж ахуй эрхлэх сонирхлыг бий болгох малчдын мал аж ахуй эрхлэх, экологийн өөрчлөлтөнд дасан зохицох, байгаль орчноо хамгаалах, мэдээлэл авах, орчин үеийн технологийг мал аж ахуйд хэрэглэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, малжуулах ажлыг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор хэрэгжүүлэх

3.9 Ажил идэвхтэй хайгч оюутан, залуучууд, ажил олгогчдын хамтарсан уулзалтыг зохион байгуулж, цагийн болон байнгын ажлын байранд зуучлах зуучлалын үйлчилгээг өргөжүүлж, ажил олгогчдыг дэмжих, залуучуудыг ажил хөдөлмөрт бэлтгэхэд туслах ахмадын зөвлөх үйлчилгээг бий болгох

3.10 Гэмт хэрэгт өртөж, нийгмээс тусгаарлагдсан залуучуудад амьдрах ур чадвар, аж төрөх ухааны сургалт, сэтгэлзүй, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх хөтөлбөрт үйлчилгээг нэвтрүүлэх, хорих байгууллагаас суллагдах үед ажлын байраар хангах талаар хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачлагыг дэмжих

3.11 Сумдын залуучуудын нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлж, тэдний хэрэгцээ шаардлагад тулгуурласан мэдээ мэдээлэл, төрийн үйлчилгээг хүргэх “Хөгжлийн хөтөч” өдөрлөгийг сумдад 2 жилд нэг удаа зохион байгуулах

#### **4. Залуучуудад амьдрах ухааны зөв дадал олгож, залуу гэр бүлд дэмжлэг үзүүлэх**

4.1 Залуучуудыг гэр бүл, эцэг эх болоход бэлтгэх, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдээ хүмүүжлийн эерэг аргаар өсгөх мэдлэг чадвар олгох сургалт, сурталчилгаа, зөвлөх үйлчилгээг Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан тогтмол зохион байгуулах

4.2 Залуучуудад бэлэнчлэх, ядуу байхаас зайлсхийх сэтгэлгээг төлөвшүүлэх, амьжиргаагаа дээшлүүлэх, амьдралд гарч болох эрсдлээс хамгаалах мөн орон нутгийн хөгжилд залуучуудын оролцоог хангасан төсөлт ажлуудыг дэмжих

4.3 Залуучуудыг амьдралд бэлтгэхэд нөлөөлөх үйл ажиллагааг ахмад үе, эцэг эхийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах

4.4 Залуу гэр бүлийг орон сууцжуулах, хямд өртөг бүхий орон сууц худалдан авах, хүүгийн хөнгөлөлттэй зээл олгох, түрээслэхэд тодорхой болзол бүхий тэтгэлэг, урамшууллын дэмжлэг үзүүлэх, орон байрны нөхцлөө сайжруулах талаар хамтран ажиллах залуучуудын санал санаачлагыг дэмжих замаар залуучуудын амьдралын чанарыг дээшлүүлэх

4.5 Хүүхэд харах, асрах, хөгжүүлэх, сувилах үйлчилгээ үзүүлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хөхиүлэн дэмжиж, залуу гэр бүлийг ажил хөдөлмөр эрхлэх нөхцлийг бүрдүүлэх

4.6 Хууль эрх зүй, гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, уламжлалт зан заншлын /угийн бичиг хөтлөх/ талаар залуучуудад зориулсан телевизийн нэвтрүүлэг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх

4.7 Залуу гэр бүл чөлөөт цагаа хамтдаа өнгөрүүлэх, амрах, алжаал тайлах таатай орчин бүрдүүлэх хүрээнд “Хайрын төгөл” /гудамж/ байгуулах

4.8 Гэр бүлийн үнэ цэнэ, аз жаргалтай агшныг мөнхлөх, эерэг харилцааг бий болгох, залуу гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор Гэр бүлийн өдөртэй болох, энэ өдрөөр өмчийн бүх хэвшлийн нийгмийн үйлчилгээний байгууллагууд гэр бүлд зориулсан хөнгөлөлт урамшуулалтай үйлчилгээ үзүүлдэг байх

#### ***Арав. Хөтөлбөрийн санхүүжилт:***

- Орон нутгийн хөгжлийн сан
- Сум хөгжүүлэх сан
- Улс, орон нутгийн төсөв
- Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн дэмжлэг

- Бусад эх үүсвэр

**Арван нэг. Хяналт, шинжилгээ үнэлгээ:**

Сумын Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагууд өөрийн чиглэлийн үйл ажиллагааны хүрээнд үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулан гарааны үнэлгээ хийх ба үр дүнгийн үнэлгээг жил бүр хагас, бүтэн жилээр хийж, ахиц өөрчлөлтийг тооцож ажиллана. Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, хөтөлбөрийн завсрын болон эцсийн шатны үнэлгээг Засгийн газраас баталсан нийтлэг журмын дагуу гүйцэтгэнэ.

**Арван хоёр. Хөтөлбөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлт:**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Цагдаагийн газрын болон 2016 оны аймгийн Статистик тоон мэдээллийг суурь болгон авч үзнэ.

№	Хөтөлбөрийн хэрэгжүүлэх зорилтууд болон голлох шалгуур үзүүлэлтүүд	Суурь үзүүлэлт	Хүрэх түвшин	
		2016 он	2017-2018 он	2019-2020 он
<b>Зорилт 1.</b> Аюулгүй амьдрах, хөгжих ээлтэй орчинг бүрдүүлэх замаар орон нутгийн хөгжилд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх				
1	Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан залуучуудын тоо /18-35/	6682 /давхардсан тоогоор/	14000	20000
2	Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тоо	180	50% бууруулна	Тэглэнэ
3	Дохионы хэлний орчуулагчтай байгууллагын тоо	Төрийн 8 байгууллага	Төрийн 14 байгууллага, үйлчилгээний 15 байгууллага /банк, үүрэн холбоо/	Нийт 50 байгууллага
4	Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд үйлчлүүлэх орц, гарцтай байгууллагуудын тоо	судалгаа байхгүй	30%	40%
5	Залуучуудад зөв зан үйлийг үлгэрлэх залуучуудын тоо	60	500-аас дээш	1000-аас дээш
<b>Зорилт 2.</b> Залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл чийрэг бие бялдартай, бүтээлч залуучуудыг бэлтгэх				
1	Залуучуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд хамрагдсан тоо /хувь/	39901/28.9%/	60%	100%
2	Залуучуудын халдварт өвчний тохиолдлын хувь /18-35 насны хооронд/	1427 /54.4%/	50%	тэглэнэ



<b>Зорилт 3. Залуучуудын сурч, хөгжих, хөдөлмөрлөх таатай нөхцлийг бүрдүүлэх</b>				
1	Их, дээд, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Судлагдаагүй 30 хувь	40 хувь	70 хувь
2	Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын эзлэх хувь	20	30-аас хувь дээш	40-ээс дээш хувь
3	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан залуучуудын тоо	200	240-өөс дээш	300-аас дээш
4	Хөдөлмөр эрхэлдэггүй, ажил идэвхитэй хайгч залуучуудын тоо/ хувь	1090	1050	1000
<b>Зорилт 4. Залуучуудад амьдрах ухааны зөв дадал олгож, залуу гэр бүлд дэмжлэг үзүүлэх</b>				
1	Залуу гэр бүлийн салалтын эзлэх хувь	1.3	0.8	Тэглэнэ
2	Өөрийн өмчийн орон сууцанд амьдарч буй залуучуудын тоо	судлагдаагүй	10%	30%
3	Чөлөөт цагаа гэр бүлээрээ өнгөрүүлэх ая таатай орчны тоо	5	7-оос доошгүй	10-аас доошгүй
<b>Залуучуудад чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ</b>				
1	Залуучуудын хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ		Үе шаттай нэмэгдүүлнэ	
2	Залуучуудын хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ	50 сая	Үе шаттай нэмэгдүүлнэ	
3	Бусад эх үүсвэрээс үзүүлсэн хөрөнгийн хэмжээ	26 сая	Үе шаттай нэмэгдүүлнэ	